



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх, 48.7 дахь, 48.10 дахь хэсэг, Хуульчдын холбооны дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хуульчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчдын мэргэжлийн дүрэм, ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэд, байгууллагаас гаргасан гомдлыг шийдвэрлэх журам боловсруулах ажлын хэсэг байгуулж, журмын төслийг Зөвлөлд танилцуулахыг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч /П.Одгэрэл/-д даалгасугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Ерөнхийлөгч /П.Одгэрэл/-д, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг Тамгын газар /Ш.Жолбарс/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

П.ОДГЭРЭЛ

